



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2024/264-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:Enkhtuyach@audit.gov.mn">Enkhtuyach@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум 2024 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:Batmunkhb@audit.gov.mn">Batmunkhb@audit.gov.mn</a> Аудитор: Б.Наранцэцэг Утас: 7036-3047 Цахим хаяг: <a href="mailto:Narantsetsegba@audit.gov.com">Narantsetsegba@audit.gov.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10-12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10-11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11-12
4. Аудитын тайлан	13-14
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. Аудитын илрүүлэлт	15
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	16

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХҮЕГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,  
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГА Л.ЗОРИГТБААТАР ТАНАА

2024.02.19 № ЦА-2024/264-НА-СТА-ТМЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 6 хөтөлбөр хэрэгжүүлэхээр 1,235,877.0 мянган төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр 1,126,604.4 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, 109,272.6 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд “Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд Дэлхийн банкны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн систем болох E-Job платформыг улсын хэмжээнд нэвтрүүлж, хөгжүүлэлтийн үе шатны ажил хийгдэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь 1 удаа хуралдсан боловч эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн дэмжлэгийг төлүүлэх зэргээр үр нөлөө бүхий шийдвэр гаргаж, хэрэгжүүлээгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>1,059,058,010.00</b>	<b>1,387,731,500.00</b>
33	<b>АВЛАГА</b>	<b>1,059,058,010.00</b>	<b>1,387,731,500.00</b>
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	1,057,707,370.00	1,274,686,850.00
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	579,519,210.00	737,546,460.00
33705	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	84,076,400.00	119,888,600.00
33706	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	199,898,660.00	186,807,690.00
33717	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	119,085,000.00	182,560,000.00
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	66,796,100.00	42,054,100.00
33730	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	8,332,000.00	5,830,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,350,640.00	113,044,650.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>1,059,058,010.00</b>	<b>1,387,731,500.00</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>1,059,058,010.00</b>	<b>1,387,731,500.00</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,059,058,010.00</b>	<b>1,387,731,500.00</b>
51200	Хуримтлагдсан үр дүн	1,059,058,010.00	1,387,731,500.00
51210	Өмнөх үеийн үр дүн	864,746,355.00	1,057,707,370.00
51220	Тайлант үеийн үр дүн	194,311,655.00	330,024,130.00
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b>	<b>1,059,058,010.00</b>	<b>1,387,731,500.00</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,326,523,236.00</b>	<b>1,361,328,464.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>76,019,036.00</b>	<b>1,361,328,464.00</b>
<b>1200</b>	<b>Өмчийн орлого</b>	<b>76,019,036.00</b>	<b>1,361,328,464.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>76,019,036.00</b>	<b>1,361,328,464.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	0.00	278,333,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	76,019,036.00	335,304,464.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	0.00	747,691,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,250,504,200.00</b>	<b>0.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,250,504,200.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,250,504,200.00	0.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>1,132,211,581.00</b>	<b>1,031,304,334.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,132,211,581.00</b>	<b>1,031,304,334.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,210,000.00</b>	<b>43,589,200.00</b>
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,210,000.00	43,589,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,210,000.00	43,589,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,129,001,581.00</b>	<b>987,715,134.00</b>
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	74,759,036.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,639,036.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	15,120,000.00	0.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>0.00</b>	<b>125,451,464.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	125,451,464.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>692,522,860.00</b>	<b>503,248,520.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	692,522,860.00	503,248,520.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>361,719,685.00</b>	<b>359,015,150.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	361,719,685.00	359,015,150.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>194,311,655.00</b>	<b>330,024,130.00</b>
<b>6</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)</b>	<b>194,311,655.00</b>	<b>330,024,130.00</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,328,019,486.00</b>	<b>1,361,328,464.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>77,515,286.00</b>	<b>1,361,328,464.00</b>
<b>1200</b>	<b>Өмчийн орлого</b>	<b>77,515,286.00</b>	<b>1,361,328,464.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>77,515,286.00</b>	<b>1,361,328,464.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	0.00	278,333,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	76,019,036.00	335,304,464.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,496,250.00	747,691,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,250,504,200.00</b>	<b>0.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,250,504,200.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,250,504,200.00	0.00
<b>14</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>	<b>502,542,735.00</b>	<b>507,020,520.00</b>
145	Бусад орлого (олз)	502,542,735.00	507,020,520.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>1,830,562,221.00</b>	<b>1,868,348,984.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,830,562,221.00</b>	<b>1,868,348,984.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,210,000.00</b>	<b>43,589,200.00</b>
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,210,000.00	43,589,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,210,000.00	43,589,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,827,352,221.00</b>	<b>0.00</b>
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	76,109,676.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	60,989,676.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	15,120,000.00	0.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>0.00</b>	<b>125,451,464.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	125,451,464.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>692,522,860.00</b>	<b>503,248,520.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	692,522,860.00	503,248,520.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,058,719,685.00</b>	<b>1,083,015,150.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,058,719,685.00	1,083,015,150.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)</b>	<b>(502,542,735.00)</b>	<b>(507,020,520.00)</b>
<b>9</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>502,542,735.00</b>	<b>507,020,520.00</b>
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	502,542,735.00	507,020,520.00
<b>10</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)</b>	<b>502,542,735.00</b>	<b>507,020,520.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Бусад	Дүн
1	2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	-	1,059,058,010.00	-	1,059,058,010.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
6	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	1,059,058,010.00	-	1,059,058,010.00
7	2023 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	-	1,059,058,010.00	-	1,059,058,010.00
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(1,350,640.00)	-	(1,350,640.00)
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	1,057,707,370.00	-	1,057,707,370.00
10	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
11	Тайлант үеийн үр дүн	-	330,024,130.00	-	330,024,130.00
12	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	1,387,731,500.00	-	1,387,731,500.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>50,000,000.00</b>	<b>125,451,464.00</b>	<b>(75,451,464.00)</b>	<b>251</b>
120	Нийтлэг татварын бус орлого	50,000,000.00	125,451,464.00	(75,451,464.00)	251
120010	Төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>50,000,000.00</b>	<b>125,451,464.00</b>	<b>(75,451,464.00)</b>	<b>251</b>
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,235,877,000.00</b>	<b>1,126,604,350.00</b>	<b>109,272,650.00</b>	<b>91.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,235,877,000.00</b>	<b>1,126,604,350.00</b>	<b>109,272,650.00</b>	<b>91.2</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>57,200,000.00</b>	<b>43,589,200.00</b>	<b>13,610,800.00</b>	<b>76.2</b>
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	57,200,000.00	43,589,200.00	13,610,800.00	76.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,200,000.00	43,589,200.00	13,610,800.00	76.2
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,178,677,000.00</b>	<b>1,083,015,150.00</b>	<b>95,661,850.00</b>	<b>91.9</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,178,677,000.00	1,083,015,150.00	95,661,850.00	91.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,178,677,000.00	1,083,015,150.00	95,661,850.00	91.9
<b>3</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>803,624,355.00</b>	<b>507,020,520.00</b>	<b>296,603,835.00</b>	<b>63</b>
32	ЗГ-ын гадаадын төслийн зээл	803,624,355.00	507,020,520.00	296,603,835.00	63
321102	Үндсэн төлбөр (ЗГ-ын дотоод зээл)	<b>803,624,355.00</b>	<b>507,020,520.00</b>	<b>296,603,835.00</b>	<b>63</b>
<b>3</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,235,877,000.00</b>	<b>1,235,877,000.00</b>	-	<b>100</b>
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,235,877,000.00	1,235,877,000.00	-	100

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь “Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн талаар төрөөс баримталж буй цоги бодлогыг орон нутагт чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх замаар иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчинг бий болгож амжиргааны түвшинг дээшлүүлэхэд оршино” гэсэн зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд “Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд тулгуурлан нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх замаар халамжаас-хөдөлмөрт шилжих нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх явдал юм.” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар 03-ны өдрийн 01 дүгээр “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 оны үйл ажиллагаа” тогтоол,
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон гэх мэт.

Тус сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ХХҮЕГ-ын “Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газар”-аас хяналт тавьж ажилладаг бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлж байна.

Тайлант онд ХХҮГ-ын Захиргаа, хяналтын хэлтсээс хөтөлбөрийн хэрэгжилт, эргэн төлөлтөд хяналт хийж, эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн болон график зөрчилтэй иргэдэд мэдэгдэл хүргүүлэх зэрэг ажлыг зохион байгуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/289 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 328,673.5 мянган төгрөгөөр буюу 31.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,059,058.0	1,387,731.5	328,673.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,059,058.0</b>	<b>1,387,731.5</b>	<b>328,673.5</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,059,058.0	1,387,731.5	328,673.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,059,058.0</b>	<b>1,387,731.5</b>	<b>328,673.5</b>

Авлага дансны үлдэгдэл 328,673.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд олгосон 724,000.0 мянган төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй дэмжлэгээр нэмэгдэж, дэмжлэгийн эргэн төлөлт 507,020.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн зэргээс голлон шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд гүйлгээ хийгдээгүй бөгөөд 100130017410 дансыг хаасан байна.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2023 оны төсвийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг 30,000.0 мянган төгрөгөөр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас олгох зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг 1,492,542.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналын нийт эх үүсвэрийг 237,625.2 мянган төгрөгөөр бууруулж *Иэмэгтэйчүүдийн болон залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүжилтийг хассан*, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг 50,000.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас олгох санхүүжилтийг 1,234,917.0 мянган төгрөг болгон бууруулж баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 11 дүгээр сард төсвийн зохицуулалт хийж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох санхүүжилтийг 960.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 1,235,877.0 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг 50,000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн нь гүйцэтгэлээр 125,451.5 мянган төгрөг орж, улсын төсвийн дансанд бүрэн төвлөрүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,235,877.0 мянган төгрөгийг улсын төсвөөс авч урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,126,604.4 мянган төгрөг буюу 91.2 хувьтай байгаа нь нийт зардлыг 109,272.6 мянган төгрөгөөр хэмнэж, хэмнэлтийг улсын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	4,500.0	1,200.0	3,300.0	26.7
2	ХБИ-ийн ажлын байрыг дэмжих	199,837.0	186,145.3	13,691.7	93.1
3	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	24,980.0	10,273.4	14,706.7	41.1
4	Хөдөлмөрт бэлтгэх сургалт	42,620.0	35,323.0	7,297.0	82.9
5	Аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг	726,400.0	680,999.8	45,400.2	93.8
6	Түр ажлын байрыг дэмжих	184,840.0	170,273.7	14,566.3	92.1
7	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардал	52,700.0	42,389.2	10,310.8	80.4
	<b>Дүн</b>	<b>1,235,877.0</b>	<b>1,126,604.4</b>	<b>109,272.6</b>	<b>91.2</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн авлагын данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01/25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,132,211.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **11,322.1** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор сангийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг зориулалтын дагуу зарцуулж, батлагдсан төсвийн хүрээнд ажиллан өр төлбөргүй тайлагнагдсан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих нийт 151 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус сангийн 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цахим төлбөрийн баримт болон Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд хэрэгжилт 100.0 хувьтай байна.

*Хүснэгт 4. Зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	7,278.5	2	7,278.5	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>7,278.5</b>	<b>2</b>	<b>7,278.5</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлын улмаас санхүүгийн дэмжлэгийн шалгарсан төсөл, дэмжлэгийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг газар дээр нь шалгах боломжгүй байсан учир дараагийн аудитаар тулган баталгаажуулах нь зүйтэй юм.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой алдаа илрээгүй болно.

Аудитаар 123,410.6 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч зөвлөмж өгсөн.

### 5.1 Зөвлөмж

#### Авлагын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр олгосон төсөл хөтөлбөрийн эргэн төлөгдөх графикт хугацаа дууссан 62 иргэний 123,410.6 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Үүнээс залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зээлд 2018-2019 онд олгосон 8 иргэний 42,054.1 мянган төгрөгийн, ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 2017-2020 онд олгосон 24 иргэний 52,258.8 мянган төгрөгийн зээлийн төлөлт огт хийгдээгүй байна. Энэ нь аж ахуй, бизнес эрхлэгч иргэнд эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох гэрээний 3 дугаар зүйлийн 3.10-т “Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж, хавсралтад тусгагдсан эргэн төлөлт хийх хуваарийн дагуу санхүүгийн дэмжлэгийг эргэн төлнө.” гэж заасныг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал	Тоо	Дүн
Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулаагүй.	1	123,410.6					1	123,410.6				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>123,410.6</b>					<b>1</b>	<b>123,410.6</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								